



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/374

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Рашаант сумын нутаг дэвсгэрт 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байгалийн гамшигт үзэгдлийн улмаас Өвөрхангай аймгаас оторлож очсон малчид буцах замдаа гамшигт өртөж, отрын мал хорогдсон тул малын сэг зэм устгах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, нүх ухаж, дарж булахад шаардагдах 9,775,440 (есөн сая долоон зуун далан таван мянга дөрвөн зуун дөч) төгрөгийн зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг Гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСА Г ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0722

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар
сарын 08-ны өдрийн 1197 дугаар
захирамжийн хавсралт



ГАМШИГТ ӨРТСӨН МАЛЫН СЭГ ЗЭМИЙГ УСТГАХ, АРИУТГАЛ
ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ ХИЙХ АЖЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Ажиллах хүн	-	10 хүн x 7 өдөр x 50,000	3,500,000
2.	Дизель түлш	216 литр	3840	829,440
3.	Машины хөлс	3	350,000	1,050,000
4.	Бээлий	70 ширхэг	3000	210,000
5.	Маск	140 ширхэг	500	70,000
6.	Нүх ухах ковшны түлш	150 литр	3840	576,000
7.	Ковшны хөлс	-	-	300,000
8.	Хөдөлмөр хамгааллын хувцас	100 ширхэг	18,500	1,850,000
9.	Ариутгалын бодис	30 кг	38,000	1,140,000
10.	Хлорын шохой	50 кг	5000	250,000
Нийт дүн				9,775,440

-oOo-